



САНГИЙН ЯАМ

УУРХАЙН ХААЛТ БОЛОН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮЕИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АРГАЧЛАЛ

УУРХАЙН ХААЛТ БОЛОН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮЕИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АРГАЧЛАЛ

АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.

2.1. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үеийг нягтлан бодох бүртгэл ашиглагддаг гол стандартуудын хураангуй

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР ДӨРӨВ. ҮНДСЭН ЗАРЧИМ

ТАВ. УДИРДЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

ЗУРГАА. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АРГАЧЛАЛ

6.1. Ерөнхий мэдээлэл

6.2. Анхны хэмжилт ба дискаунт

6.3. Нөхөн сэргээлтийн нөөцийн анхны хүлээн зөвшөөрөлт

6.4. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн бүртгэл

ДОЛОО. ТАЙЛБАР, ЖИШЭЭ

НАЙМ. САНХҮҮГИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ОРОЛЦОО

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү аргачлал нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх санхүүгийн тайланд нөхөн сэргээлтийн нөөцийг хэзээ, хэрхэн хүлээн зөвшөөрөх, удирдлагын үүрэг ба хариуцлагын талаар аргачлалаар хангах зорилготой.
- 1.2. Энэхүү аргачлал нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх болон уурхайтай холбоотой хөрөнгө, дэд бүтцийг буулгах, зайлуулахад шаардлагатай тооцоолж буй зардлыг ирээдүйн нөхөн сэргээлтийн зардалд оруулах ба энэ нь тухайн өдрийг хүртэл эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх өнөөгийн үүрэг хариуцлага, нөхөн сэргээлтийн нөөцийн хүлээн зөвшөөрөлт, нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнах, тооцоолох арга зүйг тодорхойлно
- 1.3. Энэхүү аргачлалыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт(СТОУС), Монгол Улсын Сангийн яамнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн журам, заавар, аргачлалууд, Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам, салбарын стандартуудын хамтаар ашиглана.
- 1.4. Энэхүү аргачлал нь одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон дүрэм журмыг дэмжих зорилготой ба тэдгээрийг орлохгүй болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү аргачлалыг уул уурхайн олборлолт эсвэл олборлолт-хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийг нягтлан бодох бүртгэлдээ тусгахдаа ашиглана.
- 2.2. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн нөөц сангийн нягтлан бодох бүртгэлд ашиглагддаг гол стандартуудын хураангуй:

Стандарт	Нэр	Зорилго
НББОУС 16	Үндсэн хөрөнгө	Энэхүү стандартын зорилго нь аж ахуй нэгж өөрийн үндсэн хөрөнгөндөө хийсэн хөрөнгө оруулалт болон тэрхүү хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар олж авах боломжтой байдлаар үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлоход оршино. Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнийн тодорхойлолт болон хөрөнгөтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрөх элэгдлийн зардал ба үнэ цэний бууралтын гарзын тооцоололт юм.
НББОУС 37	Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө	Энэ стандартын зорилго нь нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгөнд тохирох хүлээн зөршөөрөлтийн шалгуур ба хэмжилтийн суурийг мөрдсөн бөгөөд тэдгээрийн шинж төрөл, хугацаа, дүнг ойлгох боломжийг хэрэглэгчдэд

		олгох хангалттай мэдээллийг тодруулсан эсэхийг ханган магадлахад оршино.
НББОУС 12	Орлогын албан татвар	Энэхүү стандартын зорилго нь орлогын албан татварыг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлоход оршино. Орлогын албан татварын нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь дараах зүйлсийн одоогийн болон ирээдүйн татварын үр нөлөөг хэрхэн бүртгэх эсэх явдал байдаг. (i) Аж ахуйн нэгжийн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн (өр төлбөрийн) дансны үнийн ирээдүйн нөхөлт (барагдуулалт); (ii) Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн тухайн тайлант хугацааны ажил гүйлгээ ба бусад үйл явдлууд.
СТОУТХ 1	Хөрөнгийг ашиглалтаас хасах, нөхөн сэргээх болон тэдгээртэй ижил өр төлбөрийн өөрчлөлт	Энэхүү тайлбарыг ашиглалтаас хасах, нөхөн сэргээх болон тэдгээртэй ижил өр төлбөрийн хэмжилтэд гарсан аливаа өөрчлөлтийг бүртгэхэд мөрдөнө. Энэ өр төлбөр нь (i) НББОУС 16-ын дагуу хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар эсвэл (ii) НББОУС 37-ын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрсөн өр төлбөр байна.
СТОУТХ 5	Хөрөнгийг ашиглалтаас хасах, сэргээн босгох болон байгаль орчны нөхөн сэргээлтэд зориулан байгуулсан сангаас ашиглах эрх	Энэхүү тайлбарыг хөрөнгийн нөхөн сэргээлтийн сантай холбоотой ашиг сонирхлыг тухайн санд хөрөнгө төвлөрүүлж буй аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд бүртгэхэд мөрдөнө. Тухайн сан нь тусдаа хуулийн этгээдээр зохицуулагддаг эсвэл санд хөрөнгө төвлөрүүлж буй аж ахуйн нэгжийн ашиглалтыг хязгаарласан шинж чанартай байж болно.

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

- 3.1. Энэхүү аргачлалын хувьд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- Нөөц гэдэг нь тодорхой бус хугацаа буюу дүн бүхий өр төлбөр юм. (НББОУС 37, параграф 10).
 - Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бөгөөд түүний хүлээгдэж буй барагдуулалтаар эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг тухайн аж ахуйн нэгжээс зарцуулахад хүргэх уг аж ахуйн нэгжийн одоогийн үүрэг юм (НББОУС 37, параграф 10).

- Үүрэг хүлээлгэх үйл явдал гэдэг нь тухайн үүргийг барагдуулахаас өөр бодит сонголтгүй болоход аж ахуйн нэгжийг хүргэдэг, хуулиар хүлээсэн үүрэг эсвэл гэрээний бус үүрэг үүсгэдэг үйл явдал юм (НББОУС 37, параграф 10).
- Хуулиар хүлээсэн үүрэг гэдэг нь дараах зүйлсээс үүсдэг үүрэг юм:
 - Гэрээ (түүний илэрхий буюу далд утгатай нөхцөлөөр);
 - Хууль тогтоомж; эсвэл
 - Хуулийн бусад үйлчлэл (НББОУС 37, параграф 10).
- Гэрээний бус үүрэг гэдэг нь дараах тохиолдолд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүнд үүсдэг үүрэг юм:
 - өнгөрсөн практикийн тогтсон хэв маяг, хэвлэн нийтэлсэн бодлого буюу хангалттай тодорхой заасан одоогийн мэдэгдлээр тухайн аж ахуйн нэгж нь зарим хариуцлагыг хүлээнэ гэдгээ бусад талуудад илэрхийлсэн байх;
 - үүний үр дүнд, уг аж ахуйн нэгж нь тэдгээр хариуцлагыг биелүүлнэ гэсэн бодит хүлээлтийг нөгөө талдаа бий болгосон байх (НББОУС 37, параграф 10).
- Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд:
 - бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба
 - нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй (НББОУС 16, параграф 6).
- Дансны үнэ гэдэг нь аливаа хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэний бууралтын гарзыг хассаны дараах хөрөнгийг хүлээн зөвшөөрч байгаа дүн юм (НББОУС 16, параграф 6).
- Нягтлан бодох бүртгэлийн ашиг гэдэг нь татварын зардлыг хасахын өмнөх тухайн тайлант хугацааны ашиг эсвэл алдагдал юм (НББОУС 12, параграф 5).

3.2. Энэ аргачлалд дараах товчилсон үгийг ашигласан:

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУТХ	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хороо
ӨҮЦ	Өнөөгийн Үнэ Цэнэ
ИҮЦ	Ирээдүйн Үнэ Цэнэ

ДӨРӨВ. ҮНДСЭН ЗАРЧИМ

- 4.1. Нөөцийн шавхагдал эсвэл өөрчлөн байгуулах арга хэмжээ авах болон бусад шалтгаанаар уурхайг хаадаг. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх болон уул уурхайтай холбоотой хөрөнгө, дэд бүтцийг буулгах, зайлуулахад шаардлагатай тооцоолж буй зардлыг ирээдүйн нөхөн сэргээлтийн зардалд оруулах ба энэ нь тухайн өдрийг хүртэл эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх өнөөгийн үүрэг хариуцлагаар хязгаарлагдана.
- 4.2. Аж ахуйн нэгж нь тухайн өдрийн байдлаар эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх, хуулийн эсвэл үүсмэл өнөөгийн үүрэг хариуцлага хүлээж байгаа бол

уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийг СТОУС-д заасны дагуу хүлээн зөвшөөрнө. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн нөөц санг НББОУС 37-д заасны дагуу байгуулна.

- 4.3. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн нөөцийн анхны хэмжилтээрх дүн нь санхүүгийн тайлант хугацааны эцэст хүлээж буй өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах тооцоолсон ирээдүйн зардлын өнөөгийн үнэ цэнэ байна.
- 4.4. Ирээдүйд гарах уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын мөнгөн дүнг ихэвчлэн шууд тодорхойлох боломжгүй байдаг тул ирээдүйд гарах нөхөн сэргээлтийн өртгийн тооцооллыг уул уурхайн компанийн удирдлагаас хийж байхыг шаардсан байдаг.
- 4.5. Ирээдүйд уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийх зардлын тооцоолол нь удирдлагын хийдэг тооцоолол байдаг. Аж ахуйн нэгжийн удирдлага нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгагдах тооцоололтой холбоотой ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээдэг. Үүнд, ирээдүйд уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийх зардлын тооцоолол, түүний иж бүрэн байдал хамаарна. Мөн ирээдүйд уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийх зардлыг тооцохдоо удирдлага хөндлөнгийн зөвлөхийг ашигласан бол тухайн зөвлөхийн ажлын үр дүн болон ур чадварыг үнэлэх хариуцлагыг мөн удирдлага хүлээдэг. Тухайлсан тооцооллын талаарх хөндлөнгийн зөвлөхийн бэлтгэсэн ажлын үр дүнгийн тохиромжтой байдал болон хэрэглээ нь удирдлагын үүрэг хариуцлагад хамаарна.

ТАВ. УДИРДЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. Хэдийгээр ирээдүйд уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийх зардлын мөнгөн дүнг ихэвчлэн шууд тодорхойлох боломжгүй байдаг ч уул уурхайн олборлолт, хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн удирдлага ирээдүйд гарах нөхөн сэргээлтийн зардлыг тооцоолох үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийхтэй холбоотой зардлын мөнгөн дүнг хэмжиж, тооцоолохын тулд удирдлага зохистой аргазүй, таамаглал болон өгөгдлийг сонгон ашиглах шаардлагатай.
- 5.2. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийхтэй холбоотой зардлыг тооцоолох нь нарийн төвөгтэй байдаг бөгөөд тусгай нарийн мэргэжлийн мэдлэг шаарддаг. Нөхөн сэргээлтийн зардлыг шинээр тооцоолох эсвэл өмнөх тооцоололд томоохон хэмжээний өөрчлөлт оруулах, мөн уг зардлыг тооцоолоход тохиромжтой аргазүй, таамаглал ашиглахын тулд удирдлага нь тусгай мэргэжилтэн, зөвлөхүүдийг ашиглах, туслалцаа авах нь тохиромжтой юм.
- 5.3. Энэхүү тусгай нарийн мэргэжлийн мэдлэгийн хэрэгцээнээс үүдэн удирдлага нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг өмнө нь тооцоолж байсан туршлагатай, зохих ур чадвар бүхий хөндлөнгийн байгаль орчны мэргэжилтэн, эсвэл бусад зөвлөхүүдтэй гэрээ байгуулах, эсвэл дотоод мэргэжилтнийг авч ажиллуулж болно. Ихэнх тохиолдолд байгаль орчны хөндлөнгийн мэргэжилтэн эсвэл дотоод мэргэжилтэн нь нөхөн сэргээх зардлыг одоогийн үнэ (жишээлбэл: тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд өнөөгийн үнэ цэнээр ямар хэмжээний зардал гарах) дээр үндэслэн тооцдог бөгөөд энэ тооцоолсон дүнг хүлээгдэж буй инфляцын түвшнээр тохируулан тухайн зардал бодитоор гарахаар хүлээгдэж буй өдрийн үүрэг хариуцлагын мөнгөн дүнг тодорхойлдог.

- 5.4. Хөндлөнгийн эсвэл дотоод мэргэжилтнийг сонгож гэрээ байгуулахдаа дараах зүйлсийг харгалзан үзсэн байна. Үүнд:
- 1) Нөхөн сэргээлтийн зардлыг тооцоолох ур чадвар, чадамжтай байх;
 - 2) Хууль тогтоомж, журам заавар болон нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудын талаарх мэдлэгтэй байх;
 - 3) Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг тооцоолж байсан туршлага байх;
 - 4) Дотоод болон олон улсын мэргэжлийн байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэй байх.
- 5.5. Удирдлага нь хөндлөнгийн эсвэл дотоод мэргэжилтний бэлтгэсэн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцоололд ашигласан өгөгдөл болон тайланг ашиглах бол дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:
- a) Холбогдох хууль тогтоомж (тухайлбал, Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Стандарт хэмжилзүйн газраас гаргасан стандартууд)-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэх;
 - b) Нөхөн сэргээлт, уурхайг хаах арга хандлага, хувилбар нь хуулийн шаардлагуудтай нийцсэн эсэх;
 - c) Уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийхтэй холбогдон гарах зардлыг тооцоолоход ашигласан арга, таамаглал, өгөгдөл зохистой байгаа эсэх;
 - d) Тооцоололд сонгон ашигласан арга болон таамаглал нь өмнөх тайлант үеэс өөрчлөгдсөн эсвэл түүнийг өөрчлөхөөр төлөвлөж байгаа бол уг өөрчлөлт нь нөхцөл байдлын өөрчлөлт (тухайлбал, хуулийн шаардлагын өөрчлөлт) эсвэл шинэ мэдээлэл бий болсонтой холбоотой өөрчлөлт орсон эсэх;
 - e) Тухайн өгөгдөл эсвэл тайлан нь нягтлан бодох бүртгэл, тайлагналын өдрөөрх уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчны талбайг харгалзан үзсэн эсэх. Үүнд: өмнөх тайлант үеэс хойш газар, байгаль орчинд учирсан сөрөг нөлөөлөл орно;
 - f) Шаардлагатай асуудлаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, батлуулсан эсэх. Хянуулсан бол ямар тайлбар, зөвлөмж ирсэн, түүнийг тайланд хэрхэн тусгасан эсэх;
 - g) Уурхайн хаалт болон нөхөн сэргээлт хийх бусад хувилбаруудыг харгалзан үзсэн бол үнэлсэн эсэх, эсвэл эдгээр хувилбаруудыг уурхайн хаалт болон нөхөн сэргээлтэд тохиромжгүй гэж үзэн ашиглаагүй бол шалтгааны талаар дурдсан эсэх.
- 5.6. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн зорилгоорх нөхөн сэргээлтийн зардлын тооцоололд хөндлөнгийн эсвэл дотоод мэргэжилтний ашигласан арга, таамаглал болон түүний зохистой байдал, тууштай ашигласан, мөрдсөн эсэхтэй холбоотой эцсийн хариуцлагыг уул уурхайн компанийн удирдлага хүлээнэ. Мөн өмнөх тайлант үеийн тооцоололд ашигласан арга, таамаглалыг өөрчилсөн бол тухайн өөрчлөлт зохистой эсэхийг хянах зэрэг нь удирдлагын үүрэг хариуцлага болно.
- 5.7. Мөн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцоололд ашигласан аргазүйн зохистой байдал болон түүнийг тууштай ашигласан эсэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна. Хэрэв өмнөх тайлант үеэс аргазүй болон таамаглалыг

- өөрчилсөн бол тухайн өөрчлөлт тохиромжтой эсэх нь мөн удирдлагын үүрэг хариуцлага байна.
- 5.8. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцоололд ашиглах таамаглалууд нь тайлант хугацааны эцэст, санхүүгийн тайланг бэлтгэх үед боломжтой байгаа мэдээлэлд үндэслэн удирдлагаас гаргах үнэлэмжид тулгуурладаг. Үүнд, инфляцын түвшин, дискаунтын түвшний сонголт, мөн ирээдүйн нөхцөл байдал, үйл явдлын (тухайлбал, уурхайн хаалтын хугацаа, боломжит үйл ажиллагааны цар хүрээ болон мөнгөн урсгалын хугацаа) талаарх удирдлагын таамаглал хамаарна. Удирдлага нь хэд хэдэн боломжит хувилбаруудаас таамаглалыг сонгож болох ба сонгосон таамаглал нь үндэслэлтэй, дэмжигдэхүйц байна.
- 5.9. Удирдлага нь ашигласан гол таамаглалуудыг дэмжих нотолгоо, баримтжуулалтыг хийх шаардлагатай. Тухайлбал, гол таамаглалуудыг сонгохдоо удирдлагын гаргасан үндэслэл, хийсэн үнэлгээ болон бусад боломжит хувилбаруудтай харьцуулахад сонгосон хувилбар нь тухайн нөхцөл байдалд яагаад илүү тохиромжтой (эсвэл бусад боломжит хувилбарууд нь яагаад тохиромжгүй) байгаа талаарх дүгнэлт зэргийг баримтжуулах шаардлагатай.
- 5.10. Тооцооллын тодорхой бус байдлын түвшин болон ашигласан гол таамаглалуудын үндэслэлтэй байдлыг тодорхойлох үүднээс удирдлага мэдрэмжийн шинжилгээг хийх шаардлагатай. Энэхүү шинжилгээ нь уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын мөнгөн дүн болон холбогдох нөөц нь таамаглалуудыг өөрчлөхөд хэрхэн хэлбэлзэж буйг удирдлага тодорхойлно.
- 5.11. Мэдрэмжийн шинжилгээ, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн тооцооллоор ялгаатай үр дүн бүхий хэд хэдэн хувилбарууд гарч болох ч удирдлагын тооцоолол нь төвийг сахисан, бодитой, аливаа нөлөөллөөс ангид байна.
- 5.12. Удирдлага нь хууль тогтоомж, дүрэм журам, тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, эдийн засгийн болон улс төрийн орчны аливаа өөрчлөлт мөн СТОУС-ийн өөрчлөлтүүдийн нөхцөл байдал зэргийг тодорхой давтамжтайгаар хянан үзэж, шаардлагатай тохиолдолд уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг дахин тооцоолно.
- 5.13. Аргачлалын 5.12-д дурдсан нөхцөл байдлуудад /үүгээр хязгаарлагдахгүй/ өөрчлөлт орсон, өмнөх тооцооллоос хойш нэмж эвдрэлд орж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл учирсан эсэхийг харгалзан уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцооллыг шинэчлэх давтамжийг удирдлага тодорхойлно. Тайлант үе бүрийн эцэст, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн тооцоолсон зардлыг тухайн тайлант хугацаанд гарсан бага хэмжээний байгаль орчны сөрөг нөлөөлөл болон нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдэд тохируулан шинэчилнэ. Тогтмол давтамжтайгаар, тухайлбал 3-аас 5 жил тутамд, болон нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөх эсвэл эвдрэлийн түвшин эрс нэмэгдэх бүрд нөхөн сэргээлтийн зардлыг бүрэн хэмжээгээр дахин тооцоолно.
- 5.14. Өмнөх тайлант үед хийсэн тооцоолол нь үндэслэлтэй байсан эсэхийг хянахын тулд бодит үр дүнг өмнөх тооцоололтой харьцуулан буцаан хянах хяналтыг гүйцэтгэнэ. Жишээлбэл, компани тайлант үед нөхөн сэргээлт хийсэн бол өмнөх тайлант үед тооцоолсон нөхөн сэргээлтийн зардлын мөнгөн дүнг тайлант үеийн бодит зардалтай харьцуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, удирдлага нь өмнөх тайлант үед хийсэн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцооллоо бодит гарсан зардлын

үр дүнтэй харьцуулан хянах шаардлагатай юм. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн тооцоолол болон бодит зардлын зөрүү нь магадгүй одоогийн тайлант үед хийх тооцоололд залруулга хийх шаардлагатайг удирдлагад илтгэж болно.

5.15. Удирдлага нь ашигласан гол таамаглалуудыг дэмжих зорилгоор нотолгоо цуглуулан, баримтжуулалтыг хийнэ. Үүнд:

- a) сонгосон арга болон ашигласан өгөгдөл мэдээ. (бусад эх сурвалжаас авсан өгөгдөл мэдээнүүд хамаарна);
- b) боломжит үндэслэлтэй үр дүнгүүдээс (хэд хэдэн боломжит таамаглалуудыг ашиглан тооцсон үр дүнгүүд) сонгосон таамаглал, уг сонгосон таамаглал нь хамааралтай бөгөөд найдвартай өгөгдөл мэдээгээр хэрхэн тохиромжтой байдлаар дэмжигдэж байгаа талаар;
- c) үндэслэлтэй боломжит үр дүнгүүдээс сонгосон тооцооллын үр дүн;
- d) хөндлөнгийн мэргэжилтэн эсвэл дотоод мэргэжилтнүүдийн гаргасан тайлан, өгөгдөл мэдээ (хэрэв удирдлага тэдгээрийг ашигласан бол), мөн тухайн тайлан, өгөгдөл мэдээний үндэслэлтэй байдлын талаарх удирдлагын хяналт, дүгнэлт;
- e) техник эдийн засгийн үндэслэл, уурхайн төлөвлөгөө, тухайн тооцоолол хийж буй өдрийг хүртэл байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийн талаарх тайлан, Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуульд заасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт зэрэг зохицуулах байгууллагуудад хүргүүлсэн тайлан зэрэгт тусгагдсан зүйлсийг нөхөн сэргээлтийн зардлын тооцоололдоо тууштай байдлаар тусгасан эсэх.

ЗУРГАА. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АРГАЧЛАЛ

6.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 6.1.1 Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам болон эрх бүхий төрийн зохицуулагч байгууллагуудын шаардлагад үндэслэн уул уурхайн компаниуд үйл ажиллагааныхаа эцэст (зарим тохиолдолд үйл ажиллагааныхаа явцад) уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой хөрөнгө, дэд бүтцийг буулгах, зайлуулах шаардлагатай болдог.
- 6.1.2 Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль ("Ашигт малтмалын тухай хууль")-ийн дагуу хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрлийг авахдаа байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үүрэгтэй. Эдгээр төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын төв байгууллага (Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам)-д хүргүүлж, батлуулах ёстой. Дараагийн тайлант үеүдэд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт буюу хийж гүйцэтгэсэн нөхөн сэргээлт болон үйл ажиллагааны талаарх тайланг жил бүр хүргүүлэх ёстой.
- 6.1.3 Ашигт малтмалын тухай хуулийн дагуу төлөвлөж буй уурхайн хаалт болон нөхөн сэргээх арга хэмжээнүүд (тухайлбал, нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглах зорилгоор эвдэрсэн газрыг булах, хэлбэршүүлэх, шимт хөрсөөр хучих гэх мэт), тэдгээрийн нарийвчилсан тайлбар болон арга хэмжээ тус бүрийн тооцоолсон зардлыг дээр дурдсан төлөвлөгөөнүүдэд тусгасан байх ёстой.

- 6.1.4 Монгол Улсад уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхтэй холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аргачлал болон салбарын стандартуудын дагуу уурхайн хаалт болон нөхөн сэргээлт нь ихэвчлэн дараах хоёр үе шатаас бүрддэг. Үе шат бүрд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь байршил (жишээлбэл, говийн бүс, хангайн бүс) болон бусад байгаль орчны хүчин зүйлсээс хамааран ялгаатай байж болно:
1. Техникийн нөхөн сэргээлтийн (эсвэл гадаргуун байгуулалт) үйл ажиллагаанд эвдэрсэн газрыг булах, хэлбэршүүлэх, шимт хөрсөөр хучих зэрэг багтах ба эдгээр үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй;
 2. Биологийн нөхөн сэргээлтийн (эсвэл ургамалжилтыг бий болгох) үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг бий болгох, өнгөн хөрсийг ургамалжуулах, үржил шимийг сайжруулах зэрэг багтах ба эдгээр үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй.
- 6.1.5 Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг хянах, байгаль орчинд учирсан сөрөг нөлөөлөл, шинэ мэдээллийг тусгах зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг тогтмол хянаж, шаардлагатай бол тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулна.
- 6.1.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн хайгуулын эсвэл ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах жилийн төлөвлөгөөг боловсруулан, тухайн уурхай байрлаж буй сум эсвэл дүүргийн засаг даргаас зөвшөөрөл авдаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүр байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50%-тэй тэнцэх мөнгөн хөрөнгийг холбогдох сум, дүүргийн засаг захиргааны нээсэн тусгай дансанд шилжүүлдэг. Тухайн жилд төлөвлөсөн байгаль орчныг хамгаалах арга хэмжээг гүйцэтгээд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барьцаагаа буцаан авдаг. Гэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ихэвчлэн барьцаа мөнгөн хөрөнгийг буцаан авахгүйгээр дараа жил шилжүүлэх мөнгөн хөрөнгөдөө тооцуулдаг. Өөрөөр хэлбэл, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардал өмнөх жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад өөрчлөгдсөн бол зөрүү мөнгөн хөрөнгийг тусгай дансанд нэмж байршуулдаг.
- 6.1.7 Бохирдол, бохирдлын түвшнийг хянах зорилгоор байгаль орчны хамгааллын болон хяналтын үйл ажиллагааны болон нөхөн сэргээлт хийх (техникийн болон биологийн нөхөн сэргээлт) зардал нь байгаль орчныг хамгаалах жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой зардалд орсон байдаг. Уурхайн үйл ажиллагааны сүүлийн жил хүртэл байгаль орчныг хамгаалах жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд байгаль орчныг хамгаалах болон хянах үйл ажиллагаатай холбоотой ихэнх зардлууд гардаг бөгөөд нөхөн сэргээлттэй холбоотой томоохон зардлуудыг оруулаагүй байдаг. Тиймээс ихэнх жилүүдийн тусгай дансанд байршуулсан барьцаа нь нягтлан бодох бүртгэлийн нөхөн сэргээлтийн нийт нөөцтэй харьцуулахад харьцангуй бага хэмжээтэй байдаг.

- 6.1.8 Орон нутгийн засаг захиргааны тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгө нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчин болон уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг биелүүлэхийг баталгаажуулахад чиглэсэн барьцаа хэлбэртэй байдаг бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд уг мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн зорилгоор ашиглана. Тиймээс энэхүү барьцаа хөрөнгийг богино хугацаат барьцаа хөрөнгө байдлаар бүртгэлд хүлээн зөвшөөрч, богино хугацаат барьцаа хөрөнгийг бусад авлага эсвэл бусад хөрөнгө байдлаар мөнгөн зүйл гэж үзэн эргэлтийн хөрөнгөөр ангилан бүртгэнэ. Энэ нь СТОУС-ын хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах шалгуурыг хангахгүй тул СТОУТХ 5-ын дагуу барьцаа хөрөнгө нь байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг гүйцэтгэсний дараа тусгай зөвшөөрөл эзэмшигчид буцаан олгогддог гэж үзвэл уг барьцааг нөхөн сэргээлтийн нөөцөөс тусдаа хөрөнгө (жишээлбэл, бусад авлага) хэсэгт хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- 6.1.9 Тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх зарчим нь урт хугацаат нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагатай холбоотой банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, эсвэл тусгай санд хамаарна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, эсвэл тусгай санд хяналтгүй эсвэл нөлөөлөх боломжгүй гэж үзвэл, СТОУТХ 5, мөн НББОУС 37-ийн дагуу банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, эсвэл тусгай санг нөхөн төлбөрийн зориулалттай хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагаа барагдуулсны дараа санг эргүүлэн авах, мөн сангаас нөхөн төлбөр авах нь тодорхой бол санг бусад авлагаар бүртгэнэ.
- 6.1.10 Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны зардлыг тооцоолохын тулд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх зардлын үнэн зөв, тохиромжтой тооцооллыг хийж чадах туршлагатай, ур чадвар бүхий хөндлөнгийн мэргэжилтэн, зөвлөхүүдтэй гэрээ байгуулах эсвэл дотоод мэргэжилтнийг авч ажиллуулах шаардлагатай юм. Энэ нь ерөнхийдөө тухайн мэргэжилтэн байгаль орчны асуудлын талаар нарийн мэдлэгтэй байх хэрэгцээ шаардлагатай холбоотой. Үүнд, байгаль орчны эвдрэл, хорт бодисын хэмжээ, тэдгээрийн төрөл, газарзүйн онцлог, одоог хүртэл учирсан эвдрэлийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, байгаль орчныг нөхөн сэргээх зардал зэрэг хамаарна.

6.2 АНХНЫ ХЭМЖИЛТ БА ДИСКАУНТ

- 6.2.1 НББОУС 37-д нөхөн сэргээлтийн нөөцийн анхны хэмжилт гэдгийг тухайн тайлант үеийн эцэст хүлээгдэж буй өнөөгийн үүрэг хариуцлагыг ирээдүйд барагдуулахад шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолол байна гэж заасан. Тооцооллоор гарсан дүнг Үндсэн хөрөнгө, эсвэл Уул уурхайн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ба журналын бичилтийг энэхүү аргачлалын 40 дүгээр зүйлд тайлбарласан (Тайлбар жишээ 1-ийг харна уу).
- 6.2.2 Тухайн тайлагналын өдрийг хүртэл эвдрэлд орсон газар, байгаль орчны нөхцөл байдалд үндэслэн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг тооцсоны дараа холбогдох ирээдүйн мөнгөн урсгалыг түүний хүлээгдэж буй нөхөн сэргээлтийн цаг хугацааны хүчин зүйлсийг нь харгалзан өнөөгийн үнэ

- цэнэ рүү нь тохируулах шаардлагатай. Дискаунтчилан өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох нь мөнгөний цаг хугацааны үнэ цэний нөлөөг тусгах зорилготой.
- 6.2.3 Нөхөн сэргээлтийн нөөцийг тооцдог нийтлэг арга нь эхлээд үүрэг хариуцлагыг барагдуулахад шаардагдах зардлыг одоогийн үнэд суурилан үндэслэлтэйгээр тооцоод, дараа нь тухайн тооцоолсон зардлыг хэрэглээний үнийн индекс зэрэг инфляцийн хэмжигдэхүүнүүдийг ашиглан тохируулж ирээдүйн тайлант хугацаанд шаардагдах уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг тодорхойлно.
- 6.2.4 Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг одоогийн үнэд суурилан тооцоолох нь илүү найдвартай байдаг. Учир нь ирээдүйн үнийг тооцон таамаглахтай харьцуулахад ижил төстэй нөхөн сэргээлтийн ажлын өнөөгийн туршлага, ажил үйлчилгээний үнийн санал болон бусад эх үүсвэрээс одоогийн үнийг нарийн тогтоох боломж илүү байдаг. Тиймээс одоогийн үнэд суурилсан ирээдүйн зардлыг тооцоод, дараа нь ирээдүйн инфляцын хүчин зүйлээр тохируулах аргыг ашиглаж болно.
- 6.2.5 Ирээдүйн инфляцын түвшнийг макро эдийн засгийн хамгийн найдвартай таамаглалд суурилан тогтоох ба энэ инфляцын түвшин нь тухайн нөхцөл байдал болон уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн мөнгөн урсгалыг тооцоход ашигласан валютад тохирсон, уялдаатай байна. Мөн энэхүү инфляцын таамаглал нь уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын тооцоолол болон холбогдох таамаглалуудтай уялдаатай байна. Тухайлбал, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг гадаад валютаар тооцсон бол ашиглах инфляцын түвшин тухай гадаад валютын худалдан авах чадвар зэрэг үндэслэн тогтооно.
- 6.2.6 Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийг ихэвчлэн уул уурхайн үйл ажиллагааны төгсгөл үед хийдэг. Тиймээс нөхөн сэргээлтийн нөөцийн үнийн дүнгийн хувьд дискаунтын нөлөө нь ихэвчлэн материаллаг нөлөөтэй байдаг. Тооцоолсон ирээдүйн нөхөн сэргээлтийн зардлыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн үүрэг хариуцлагатай хамааралтай эрсдэлүүдийн нөлөөг тусгасан татварын өмнөх дискаунтын түвшнээр дискаунтчилна.
- 6.2.7 Ирээдүйн мөнгөн урсгал (ирээдүйн нөхөн сэргээлтийн тооцоолсон зардал нь бодитоор хэзээ гарах тухай таамаглал) нь аль хэдийн тухайн эрсдэлийн хүчин зүйлсээр тохируулагдсан бол уг хүчин зүйлийг харгалзан үзнэ. Дараах томъёог ирээдүйн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоход ашиглана:

$$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = \frac{\text{Ирээдүйн үнэ цэнэ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{үлдэж буй хугацаа}}}$$

Жишээ нь, таван жилийн дараа 100 сая төгрөгийн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардал бодитоор гарна гэж тооцсон ба дискаунтын түвшин 10% бол таван жилийн дараах 100 сая төгрөгийн өнөөгийн үнэ цэнэ 62.09 сая төгрөг байна. Үүнийг дээрх томъёог ашиглан тооцвол:

$$62.09 \text{ сая төгрөг} = \frac{100 \text{ сая төгрөг}}{(1 + 10\%)^5}$$

Цаг хугацаа өнгөрсөн/ өөрчлөгдсөний нөлөөг тусгахын тулд нөхөн сэргээлтийн нөөцийг жил бүр дискаунтын нөлөөгөөр нэмэгдүүлнэ. Дээр дурдсан жишээний нөхцөлүүд өөрчлөгдөөгүй гэж үзвэл 100 сая төгрөгийн 1

жилийн дараах үнэ цэнэ (зардал гарахаас 4 жилийн өмнө) нь 68.3 сая төгрөг болно. Дараах хүснэгтэд дээрх жишээний нөхөн сэргээлтийн нөөцийн үлдэгдэл болон санхүүгийн зардлыг жил бүрийн эцсийн байдлаар харуулсан ба ирээдүйд байгаль орчин нэмж эвдрэлд орохгүй, дискаунтын түвшин, хүлээгдэж буй мөнгөн урсгал зэрэг бусад таамаглал өөрчлөгдөхгүй гэж үзсэн:

(сая төгрөгөөр)

	Анхны хүлээн зөвшөөрөлт	... -ийн дараа				
		1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил
Нөхөн сэргээлтийн нөөц	62.09	68.3	75.13	82.6	90.9	100
Тайлант жилийн санхүүгийн зардал	тэг	6.21	6.8	7.5	8.26	9.09

Дээрх тоонууд нь зөвхөн тайлбарлах үүднээс ашигласан жишээ бөгөөд бодит тооцоолсон ирээдүйн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлын мөнгөн урсгал болон тооцоолсон дискаунтын түвшнийг ашиглах шаардлагатай юм. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн зардлын талаар доорх хэсгүүдэд тайлбарлах болно.

- 6.2.8 Мөнгөн урсгал эсвэл дискаунтын түвшний аль нэгийг эрсдэлээр тохируулна. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн өнөөгийн үүрэг хариуцлагыг барагдуулахад шаардлагатай ирээдүйн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг тооцохдоо эхлээд мөнгөн урсгалыг нь эрсдэлээр тохируулаад, дараа нь уг мөнгөн урсгалыг эрсдэлгүй хүүгийн түвшнээр дискаунтчилна.
- 6.2.9 Эрсдэлгүй хүүгийн түвшнийг Засгийн Газрын бондын хүүд суурилан тодорхойлж болох ба Засгийн Газрын бонд нь нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг барагдуулахтай холбогдон гарах тооцсон зардалтай ижил валютаар төлөгдөх, мөн төлөгдөх хугацааны хувьд ойролцоо байх ёстой. Нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлага нь ихэвчлэн урт хугацааны дараа хэрэгжихээр байдаг тул ижил хугацаатай Засгийн Газрын бондын хүүгийн мэдээлэл олдохгүй байх магадлалтай. Энэ тохиолдолд хугацааны хувьд ижил хүүгийн түвшнийг тодорхойлохын тулд хүүгийн түвшний өгөөжийн муруйг ашиглан (Засгийн Газрын бондын хүүгийн чиг хандлага, төлөв) тооцож болно. Эсвэл хугацааны хувьд хамгийн ойролцоо Засгийн Газрын бондын хүүг найдвартай, хамааралтай гэж үзвэл тухайн бондын хүүг үндэслэн эрсдэлгүй хүүгийн түвшнийг тодорхойлж болно. Монгол Улсын арилжааны банкнуудын зээлийн хүү болон банк хоорондын зээлийн хүү нь холбогдох мөнгөн урсгалыг агуулсан өр төлбөрийн эрсдэлийг илэрхийлдэггүй тул эдгээр хүүгийн түвшнийг дискаунтын түвшнээр ашиглах нь тохиромжгүй. Хэрвээ Монгол Улсын Засгийн Газар бондоо америк доллароор гаргасан, харин аж ахуйн нэгж нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагын мөнгөн урсгалаа төгрөгөөр

тооцсон гэж үзвэл валютын эрсдэлийн ялгаатай байдал болон америк доллар, төгрөг хоорондын хэлбэлзлийг тусгах зорилгоор америк доллароор гаргасан бондын түвшнийг залруулан тохируулах шаардлагатай. Ингэснээр дискаунтын түвшин болон мөнгөн урсгалын валют нь уялдаатай болох юм.

- 6.2.10 Үүрэг хариуцлагыг барагдуулахтай холбогдон гарах мөнгөн урсгалын цаг хугацааг тодорхойлохдоо холбогдох хөрөнгийн ашиглалтын жил, уул уурхайн төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг харгалзан үзэх шаардлагатай. Ашигт малтмалын нөөц, олборлолтын хэмжээ, тусгай зөвшөөрөл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон эдийн засгийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлсээс хамааран хүлээгдэж буй мөнгөн урсгалын хугацаа, хэмжээ нь өөрчлөгдөж болно.

6.3 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН НӨӨЦИЙН АНХНЫ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 6.3.1 Аргачлалын 6.2-т заасан дискаунтын нөлөөг тусгасны дараа, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нөөц болон Үндсэн хөрөнгө эсвэл Уул уурхайн хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгө эсвэл Уул уурхайн хөрөнгө нь уул уурхайн үйл ажиллагааны ирээдүйн эдийн засгийн өгөөжтэй хамааралтай өртөг байдаг. Харин нөхөн сэргээлтийн нөөц нь уурхайг хаах үед нөхөн сэргээлтийн одоогийн үүрэг хариуцлагыг барагдуулахад шаардлагатай ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байдаг.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх болон уул уурхайтай холбоотой хөрөнгө, дэд бүтцийг буулгах, зайлуулахтай холбоотой нөхөн сэргээлтийн нөөц болон хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн журналын бичилт нь дараах байдалтай байна. (Энэхүү аргачлалын Тайлбар жишээ 1-ийг харна уу).

Дт: Үндсэн хөрөнгө эсвэл Уул уурхайн хөрөнгө XXX

Кр: Нөхөн сэргээлтийн нөөц XXX

- 6.3.2 Уул уурхайн цаашид ашиглагдахгүй хөрөнгө, дэд бүтцийг буулгах, зайлуулахтай холбоотой үүрэг хариуцлагыг тухайн хөрөнгийг суурилуулсан эсвэл барьж байгуулсан үе буюу тухайн үүрэг хариуцлага бий болсон үед хүлээн зөвшөөрнө. Тухайлбал, уул уурхайн дэд бүтцийг түүний ашиглалтын хугацаа дуусах үед (ихэвчлэн уурхайн хаалтын үед) буулгах, зайлуулах ёстой байдаг ч уг дэд бүтцийг буулгах, зайлуулах үүрэг хариуцлага нь түүнийг барьж байгуулах үед үүсэх бөгөөд энэ үеийг тухайн газар, байгаль орчинд эвдрэл учирсан үе буюу өнөөгийн үүрэг хариуцлага үүсэж буй үе гэж үзнэ.
- 6.3.3 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх үүрэг хариуцлагыг эвдрэл үүссэн тухай бүрд нэмэгдүүлэн хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл, ил уурхайгаас ашигт малтмал олборлох тусам газар, байгаль орчин эвдрэлд орсон гэж үзээд үүрэг хариуцлага нь өсөн нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, нөхөн сэргээлтийн нөөцөд ирээдүйд үүсэх эвдрэлтэй холбоотой ирээдүйн үүрэг хариуцлагыг оруулахгүй юм.

6.4 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АНХНЫ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТИЙН ДАРАА ҮЕИЙН БҮРТГЭЛ

Кр: Нөхөн сэргээлтийн нөөц

XXX

- б. Ирээдүйд гарах зардлыг дахин тооцоолж, нөөцийг бууруулсан бол холбогдох хөрөнгийн дансны үнийг мөн бууруулах ба журналын бичилт нь дараах байдалтай байна:

Дт: Нөхөн сэргээлтийн нөөц

XXX

Кр: Үндсэн хөрөнгө эсвэл Уул уурхайн хөрөнгө XXX

- в. Хэрэв холбогдох хөрөнгийн дансны үнэ нь элэгдэл эсвэл үнэ цэний бууралтын улмаас тэг болж буурсан бол, нөөцийн бууралтыг дараах байдлаар ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө:

Дт: Нөхөн сэргээлтийн нөөц XXX

Кр: Бусад орлого эсвэл Нөөцийн хөдөлгөөн XXX

- 6.4.4 Урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлаас (жишээлбэл, хорт хий ялгарсны улмаас төлөвлөөгүй өр төлбөр/нөхөн төлбөр үүсэх) үүдэн гарсан зардлыг тухайн үүрэг хариуцлагыг барагдуулах бол, үнийн дүнг найдвартай тооцоолох боломжтой гэж үзсэн тайлант үед зардал ба өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

Дт: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг эсвэл Бусад зардал XXX

Кр: Нөөц эсвэл Бусад өглөг XXX

- 6.4.5 Зарим уул уурхайн компаниуд уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай холбоотой ирээдүйн зардлыг гадаад валютаар тооцоолдог. Хэрэв нөхөн сэргээлтийн нөөцийг гадаад валютаар тооцоолсон бөгөөд тухайн нөөцийг стандартын дагуу мөнгөн зүйл гэж үзэж байгаа бол гадаад валютаар илэрхийлэгдсэн нөхөн сэргээлтийн тооцоолсон нөөцийг тайлагналын өдөр бүр тухайн өдрийн албан ханшаар хөрвүүлэн, ханшийн тэгшитгэл хийнэ. Үүнээс үүсэх ханшийн тэгшитгэлийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Нөхөн сэргээлтийн нөөцийн гадаад валютаар тооцоолсон мөнгөн бус хэсгийг мөнгөн бус хөрөнгийг бүртгэхэд ашигласан түүхэн валютын ханшаар хөрвүүлнэ. Нөхөн сэргээлтийн нөөц нь:

а. мөнгөн гэдэг нь тогтмол эсвэл тодорхойлогдох боломжтой валютын нэгжээр төлбөр хийх замаар барагдуулахаар төлөвлөж байгаа өр төлбөр, жишээлбэл ажилчид төлөх төлбөр эсвэл гуравдагч этгээдэд ирээдүйд төлөх бараа эсвэл үйлчилгээний төлбөр;

б. мөнгөн бус гэдэг нь өмнө хүлээн зөвшөөрсөн мөнгөн бус хөрөнгийг ашиглах эсвэл хэрэглэх замаар барагдуулах, жишээлбэл агуулахад байгаа бараа материал ашиглах.

- 6.4.6 Нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг барагдуулахтай холбоотой нөхөн сэргээлтийн зардал бодитоор гарсан бол тухайн тайлант үе хүртэл хүлээн зөвшөөрсөн нөөцийн дүнг бууруулна.

Бэлтгэн нийлүүлэгчээс ирсэн нэхэмжлэх эсвэл холбогдох төлбөр төлөлт нь дараах байдлаар нөөцийн үнийн дүнг бууруулна:

Дт: Нөхөн сэргээлтийн нөөц
Кр: Мөнгөн хөрөнгө эсвэл Өглөг

XXX
XXX

- 6.4.7 Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үед, нөхөн сэргээлтийн үлдсэн үүрэг хариуцлагыг барагдуулахаар тооцоолсон зардлыг тогтмол хянаж, өөрчлөлт гарах бүрд шинэчилнэ. Мөн тооцоолсон зардлыг хянахдаа өмнө нь тооцоолсон уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зардлыг бодит зардалтай харьцуулсан үр дүнг мөн харгалзан үзнэ.

ДОЛОО. ТАЙЛБАР ЖИШЭЭ

Доор дурдсан хувилбарууд болон тоо мэдээлэл нь энэхүү аргачлалыг практикт хэрхэн ашиглахыг тайлбарлах зорилготой жишээ болно.

Тайлбар жишээ 1: Нөхөн сэргээлтийн нөөцийн хүлээн зөвшөөрөлт болон түүний анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн нягтлан бодох бүртгэл

Ерөнхий мэдээлэл

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь нүүрсний олборлолт болон боловсруулалт хийх гэж үзье. Нүүрс угаах үйлдвэрийн барилгыг 20X0 оны эхэнд 180 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр барьж дуусгасан. Нүүрс угаах үйлдвэрийг барьж байгуулснаар байгаль орчинд учруулсан эвдрэл болон тус үйлдвэрийг буулгаж, зайлуулахтай холбоотойгоор уурхайн ашиглалтын хугацааны эцэст буюу 9 жилийн дараа нөхөн сэргээх зардлыг одоогийн үнэд суурилан тооцвол 2 тэрбум төгрөг, энэ дүн нь 180 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын өртөгт ороогүй гэж үзье. Нүүрс угаах үйлдвэрийг түүний ашиглалтын хугацааны эцэст борлуулах боломжгүй буюу түүний үлдэх үнэ цэнэ нь тэг.

Уурхайн хөгжүүлэлтийн үе шатанд нүүрсний орд байрлах хэсгийн тодорхой талбайн өнгөн хөрсийг хуулсан. Үйлдвэрлэл эхэлсэн өдөр (20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр) уурхайн ашиглалтын хугацааны эцэст буюу 9 жилийн дараа одоог хүртэл байгаль орчинд учирсан эвдрэлийг нөхөн сэргээх өртгийг одоогийн үнэд суурилан тооцвол 9 тэрбум төгрөг болсон.

Цаашид уурхайн үйлдвэрлэлийн үе шатанд уурхайгаас нүүрс олборлох, өнгөн хөрсийг хуулах зэргээр уурхайн газар, байгаль орчин нэмж эвдрэлд орох ба холбогдох нөхөн сэргээлтийн зардлыг тухайн эвдрэл гарсан тайлант үед тооцоолно.

Компанийн удирдлага нь бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргаар уул уурхайн хөрөнгийг, шулуун шугамын аргаар үндсэн хөрөнгийг элэгдүүлэхээр шийдсэн. Нөхөн сэргээх үүрэг хариуцлагыг барагдуулах мөнгөн урсгалыг төгрөгөөр тооцсон. Энэхүү нөхөн сэргээлтийн мөнгөн урсгалын тооцоонд эрсдэлийн бусад ялгаатай хувилбаруудыг тооцон үзэж тохируулсан. Удирдлага мөнгөн урсгалын эрсдэлгүй дискаунтын түвшнийг 10% байхаар тооцсон. 20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр инфляцын түвшин 7.5% байсан ба уурхайн ашиглалтын жил буюу ирэх 9 жилийн дундаж инфляцын түвшнийг 5% байхаар тооцсон гэе.

Анхны бүртгэл

Үйлдвэрлэл эхэлсэн өдөр болох 20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр компанийн удирдлага уурхайн ашиглалтын хугацааны эцэст (20X8 оны 12 дугаар сарын 31) одоогийн эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх болон нүүрс угаах үйлдвэрийг буулгах, зайлуулахад шаардлагатай нөхөн сэргээлтийн зардлыг жилийн дундаж инфляцын түвшин болох 5%-ийг (9 жилийн турш) ашиглан дараах байдлаар тодорхойлсон:

Ирээдүйн үнэ цэнэ (ИҮЦ) = Өнөөгийн үнэ цэнэ $\times (1 + \text{инфляцийн түвшин})^{\text{хугацаа}}$

Үйлдвэрийг буулгах зардлын ИҮЦ = 2 тэрбум төгрөг $\times (1 + 0.05)^9 = 3.1$ тэрбум төгрөг

Нөхөн сэргээх зардлын ИҮЦ = 9 тэрбум төгрөг $\times (1 + 0.05)^9 = 14$ тэрбум төгрөг

Хэрэв өнөөдөр тухайн зардал гарсан бол 2 тэрбум төгрөг / 9 тэрбум төгрөг болох байсан.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй тул нүүрс угаах үйлдвэрийг буулгаж, зайлуулах болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх ирээдүйн тооцоолсон зардлын өнөөгийн үнэ цэнийг (ӨҮЦ) тооцоход дараах томъёог ашиглана.

Өнөөгийн үнэ цэнэ (ӨҮЦ) = $\frac{\text{Ирээдүйн үнэ цэнэ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{Үлдэж буй хугацаа}}}$

Үйлдвэрийг буулгах, зайлуулах зардлын ӨҮЦ = $\frac{3.1 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^9} = 1.3$ тэрбум төгрөг

Нөхөн сэргээх зардлын ӨҮЦ = $\frac{14 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^9} = 5.9$ тэрбум төгрөг

20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хөрөнгө болон түүнд холбогдох нөхөн сэргээлтийн нөөцүүдийг (хөрөнгийг чөлөөлөх үүргүүд) хүлээн зөвшөөрөхөд дараах журналын бичилтийг хийнэ.

а) Нүүрс угаах үйлдвэр болон холбогдох нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дт: Үндсэн хөрөнгө (нүүрс угаах үйлдвэр)	181.3 тэрбум төгрөг
Кр: Мөнгөн хөрөнгө / өр төлбөр	180 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (үйлдвэрийг буулгах, зайлуулах)	1.3 тэрбум төгрөг

б) Өнөөгийн байдлаар эвдрэлд орсон газар, байгаль орчин нөхөн сэргээхтэй холбоотой нөхөн сэргээлтийн нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дт: Уул уурхайн хөрөнгө (уурхайн нөхөн сэргээлт)	5.9 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (уурхайн нөхөн сэргээлт)	5.9 тэрбум төгрөг

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн бүртгэл

Уурхайн үйл ажиллагааны туршид 9 жилийн дараах ирээдүйн үнэ цэнэ болох 17.1 тэрбум төгрөгт хүрэхийн тулд дискаунтыг чөлөөлөх (нүүрс угаах үйлдвэрийг

буулгах, зайлуулах 3.1 тэрбум төгрөгийн үүрэг хариуцлага болон уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчин нөхөн сэргээх 14 тэрбум төгрөгийн үүрэг хариуцлагын нийлбэр) шаардлагатай. Уурхайн үйл ажиллагаа дуусах хүртэл дараах томъёог жил бүр ашиглана.

Нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл

$$= (\text{Тайлант жилийн } \Theta\text{ҮЦ}) - (\text{Өмнөх тайлант жилийн } \Theta\text{ҮЦ})$$

а) 20X0 оны нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл (үйлдвэрийг буулгах, зайлуулах) =

$$= \frac{3.1 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^8} - (1.3 \text{ тэрбум төгрөг}) = 0.1 \text{ тэрбум төгрөг}$$

б) 20X0 оны нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл (уурхайн нөхөн сэргээлт) =

$$= \frac{14 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^8} - (5.9 \text{ тэрбум төгрөг}) = 0.6 \text{ тэрбум төгрөг}$$

20X0 оны 12 дугаар сарын 31-ний өдөр буюу уурхайн үйл ажиллагаа эхэлснээс 1 жилийн дараа нөхөн сэргээлтийн нөөц дэх дискаунтын чөлөөлтийг дараах байдлаар бүртгэнэ.

Дт: Хүүгийн зардал	0.1 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (үйлдвэрийг буулгах, зайлуулах)	0.1 тэрбум төгрөг

Дт: Хүүгийн зардал	0.6 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (уурхайн нөхөн сэргээлт)	0.6 тэрбум төгрөг

Удирдлага нүүрс угаах үйлдвэр болон уул уурхайн хөрөнгийн элэгдлийг 9 жилийн турш жил бүр хүлээн зөвшөөрнө. Шулуун шугамын аргаар тооцсон нүүрс угаах үйлдвэрийн нэг жилийн элэгдэл нь 20.1 тэрбум төгрөг (181.3 тэрбум төгрөг / 9 жил) байна. Уул уурхайн хөрөнгийн (нөхөн сэргээлтийн хөрөнгө) элэгдэл нь нийт нүүрсний нөөц болон олборлосон нүүрсний хэмжээний хоорондын харьцаанаас шалтгаалдаг. Хэрэв компани 20X0 онд нийт нүүрсний нөөц болох 100 сая тонноос 10 сая тонныг нь олборлосон бол 20X0 оны нөхөн сэргээлтийн хөрөнгийн элэгдэл 0.6 тэрбум төгрөг (5.9 тэрбум төгрөг * 10 / 100) байна.

20X0 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нүүрс угаах үйлдвэр болон нөхөн сэргээлтийн хөрөнгийн элэгдлийг (төлөвлөсөн хэмжээний нүүрсийг угаан боловсруулж байгаа гэж үзвэл) дараах байдлаар бүртгэнэ.

Дт: Бараа материал (боловсруулсан нүүрс)	20.1 тэрбум төгрөг
Кр: Хуримтлагдсан элэгдэл (нүүрс угаах үйлдвэр)	20.1 тэрбум төгрөг

Дт: Бараа материал (боловсруулаагүй нүүрс)	0.6 тэрбум төгрөг
Кр: Хуримтлагдсан элэгдэл (нөхөн сэргээлтийн хөрөнгө)	0.6 тэрбум төгрөг

Дээрх жишээний хувьд 20X0 онд ирээдүйн нөхөн сэргээлтийн зардлын өнөөгийн үүрэг хариуцлагад нөлөө үзүүлэхүйц газар, байгаль орчинд нэмэлт эвдрэл гараагүй гэж таамагласан.

Тайлбар жишээ 2: Нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл

Ерөнхий мэдээлэл

Тайлбар жишээ 1-ийг үргэлжлүүлэн авч үзье. 20X1 онд компани нь уурхайн талбайн өнгөн хөрсийг нэмж хуулан, ил уурхайн амыг томруулсан бөгөөд ингэснээр 20X0 оны эцэстэй харьцуулахад байгаль орчинд учирсан эвдрэл нэмэгдсэн гэвэл. Байгаль орчны мэргэжилтэн 20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл эвдрэлд орсон уурхайн талбайг нөхөн сэргээх зардлыг тооцоолсон бөгөөд энэхүү зардал нь 20X1 оны үнээр 12 тэрбум төгрөг (20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх эвдрэлд орсон уурхайн талбайг нөхөн сэргээх өнөөгийн үүрэг хариуцлагыг ирээдүйд барагдуулах зардлын дүн, одоогийн үнэд суурилан тооцсон) гэж тооцсон.

20X1 онд элэгдэл тооцох арга, уурхайн ашиглалтын хугацаа, дискаунтын түвшин болон инфляцын түвшинд аливаа өөрчлөлт ороогүй гэж үзье.

Нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдлийг хүлээн зөвшөөрөх нь

20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл тайлбар жишээ 1-д дурдсан бүртгэлийн зарчим үйлчилнэ. Тиймээс 20X1 оны дискаунтын чөлөөлт болон хөрөнгийн элэгдлийг тооцоолж, бүртгэсэн.

20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр удирдлага газар, байгаль орчинд учирсан нэмэлт эвдрэл болон түүний нөхөн сэргээлтийн зардлын тооцооллыг тусгахын тулд нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Дараах томъёогоор нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдлийг тооцоолно.

Нөөцийн нэмэгдэл

$$\begin{aligned}
 &= \frac{\text{Шинээр тооцсон зардлын ИҮЦ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{Үлдэж буй хугацаа}}} \\
 &- \frac{\text{Өмнө тооцоолсон зардлын ИҮЦ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{Үлдэж буй хугацаа}}} \\
 \text{Нөөцийн нэмэгдэл} &= \frac{12 \text{ тэрбум төгрөг} \times (1 + 0.05)^7}{(1 + 0.1)^7} - \frac{14 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^7} = \\
 &= 8.7 \text{ тэрбум төгрөг} - 7.2 \text{ тэрбум төгрөг} = 1.5 \text{ тэрбум төгрөг}
 \end{aligned}$$

20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдлийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

Дт: Уул уурхайн хөрөнгө (нөхөн сэргээлтийн хөрөнгө) 1.5 тэрбум төгрөг
 Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (уурхайн нөхөн сэргээлт) 1.5 тэрбум төгрөг

20X2 оноос эхлэн хөрөнгө болон нөөцийн нэмэгдлийг харгалзан үзэж, бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргыг ашиглан тооцох элэгдэл болон дискаунтын чөлөөлөлтөөс үүсэх санхүүгийн зардлыг дахин тооцоолно.

Тайлбар жишээ 3: Нөхөн сэргээлтийн нөөцийн хүлээн зөвшөөрөлт болон түүний анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн нягтлан бодох бүртгэл

Ерөнхий мэдээлэл

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь нүүрсний олборлолт болон боловсруулалт хийх гэж үзье. Нүүрс угаах үйлдвэрийн барилгыг 20X0 оны эхэнд 180 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр барьж дуусгасан. Нүүрс угаах үйлдвэрийг барьж байгуулснаар байгаль орчинд учруулсан эвдрэл болон тус үйлдвэрийг буулгаж, зайлуулахтай холбоотойгоор уурхайн ашиглалтын хугацааны эцэст буюу 9 жилийн дараа нөхөн сэргээх зардлыг одоогийн үнэд суурилан тооцвол 2 тэрбум төгрөг, энэ дүн нь 180 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын өртөгт ороогүй гэж үзье. Нүүрс угаах үйлдвэрийг түүний ашиглалтын хугацааны эцэст борлуулах боломжгүй буюу түүний үлдэх үнэ цэнэ нь тэг.

Уурхайн хөгжүүлэлтийн үе шатанд нүүрсний орд байрлах хэсгийн тодорхой талбайн өнгөн хөрсийг хуулсан. Үйлдвэрлэл эхэлсэн өдөр (20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр) уурхайн ашиглалтын хугацааны эцэст буюу 9 жилийн дараа одоог хүртэл байгаль орчинд учирсан эвдрэлийг нөхөн сэргээх өртгийг одоогийн үнэд суурилан тооцвол 9 тэрбум төгрөг болсон.

Цаашид уурхайн үйлдвэрлэлийн үе шатанд уурхайгаас нүүрс олборлох, өнгөн хөрсийг хуулах зэргээр уурхайн газар, байгаль орчин нэмж эвдрэлд орох ба холбогдох нөхөн сэргээлтийн зардлыг тухайн эвдрэл гарсан тайлант үед тооцоолно.

Компанийн удирдлага нь гүйцэтгэлийн хувийн жингийн аргаар уул уурхайн хөрөнгийг, шулуун шугамын аргаар үндсэн хөрөнгийг элэгдүүлэхээр шийдсэн. Нөхөн сэргээх үүрэг хариуцлагыг барагдуулах мөнгөн урсгалыг төгрөгөөр тооцсон. Энэхүү нөхөн сэргээлтийн мөнгөн урсгалын тооцоонд эрсдэлийн бусад ялгаатай хувилбаруудыг тооцон үзэж тохируулсан. Удирдлага мөнгөн урсгалын эрсдэлгүй дискаунтын түвшнийг 10% байхаар тооцсон. 20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр инфляцын түвшин 7.5% байсан ба уурхайн ашиглалтын жил буюу ирэх 9 жилийн дундаж инфляцын түвшнийг 5% байхаар тооцсон гэвэл.

Анхны бүртгэл

Үйлдвэрлэл эхэлсэн өдөр болох 20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр компанийн удирдлага уурхайн ашиглалтын хугацааны эцэст (20X8 оны 12 дугаар сарын 31) одоогийн эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх болон нүүрс угаах үйлдвэрийг буулгах, зайлуулахад шаардлагатай нөхөн сэргээлтийн зардлыг жилийн дундаж инфляцын түвшин болох 5%-ийг (9 жилийн турш) ашиглан дараах байдлаар тодорхойлсон:

$$\text{Ирээдүйн үнэ цэнэ (ИҮЦ)} = \text{Өнөөгийн үнэ цэнэ} \times (1 + \text{инфляцийн түвшин})^{\text{хугацаа}}$$

$$\begin{aligned}\text{Үйлдвэрийг буулгах зардлын ИҮЦ} &= 2 \text{ тэрбум төгрөг} \times (1 + 0.05)^9 \\ &= 3.1 \text{ тэрбум төгрөг}\end{aligned}$$

$$\text{Нөхөн сэргээх зардлын ИҮЦ} = 9 \text{ тэрбум төгрөг} \times (1 + 0.05)^9 = 14 \text{ тэрбум төгрөг}$$

Хэрэв өнөөдөр тухайн зардал гарсан бол 2 тэрбум төгрөг / 9 тэрбум төгрөг болох байсан.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй тул нүүрс угаах үйлдвэрийг буулгаж, зайлуулах болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчин нөхөн сэргээх ирээдүйн тооцоолсон зардлын өнөөгийн үнэ цэнийг (ӨҮЦ) тооцоход дараах томъёог ашиглана.

$$\text{Өнөөгийн үнэ цэнэ (ӨҮЦ)} = \frac{\text{Ирээдүйн үнэ цэнэ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{Үлдэж буй хугацаа}}}$$

$$\begin{aligned} \text{Үйлдвэрийг буулгах, зайлуулах зардлын ӨҮЦ} &= \frac{3.1 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^9} \\ &= 1.3 \text{ тэрбум төгрөг} \end{aligned}$$

$$\text{Нөхөн сэргээх зардлын ӨҮЦ} = \frac{14 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^9} = 5.9 \text{ тэрбум төгрөг}$$

20X0 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хөрөнгө болон түүнд холбогдох нөхөн сэргээлтийн нөөцүүдийг (хөрөнгийг чөлөөлөх үүргүүд) хүлээн зөвшөөрөхөд дараах журналын бичилтийг хийнэ.

а) Нүүрс угаах үйлдвэр болон холбогдох нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дт: Үндсэн хөрөнгө (нүүрс угаах үйлдвэр)	181.3 тэрбум төгрөг
Кр: Мөнгөн хөрөнгө / өр төлбөр	180 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (үйлдвэрийг буулгах, зайлуулах)	1.3 тэрбум төгрөг

б) Өнөөгийн байдлаар эвдрэлд орсон газар, байгаль орчин нөхөн сэргээхтэй холбоотой нөхөн сэргээлтийн нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дт: Уул уурхайн хөрөнгө (уурхайн нөхөн сэргээлт)	5.9 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (уурхайн нөхөн сэргээлт)	5.9 тэрбум төгрөг

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн бүртгэл

Уурхайн үйл ажиллагааны туршид 9 жилийн дараах ирээдүйн үнэ цэнэ болох 17.1 тэрбум төгрөгт хүрэхийн тулд дискаунтыг чөлөөлөх (нүүрс угаах үйлдвэрийг буулгах, зайлуулах 3.1 тэрбум төгрөгийн үүрэг хариуцлага болон уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчин нөхөн сэргээх 14 тэрбум төгрөгийн үүрэг хариуцлагын нийлбэр) шаардлагатай. Уурхайн үйл ажиллагаа дуусах хүртэл дараах томъёог жил бүр ашиглана.

$$\begin{aligned} &\text{Нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл} \\ &= (\text{Тайлант жилийн ӨҮЦ}) - (\text{Өмнөх тайлант жилийн ӨҮЦ}) \end{aligned}$$

$$\begin{aligned} \text{а) } 20X0 \text{ оны нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл (үйлдвэрийг буулгах, зайлуулах)} &= \\ &= \frac{3.1 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^8} - (1.3 \text{ тэрбум төгрөг}) = 0.1 \text{ тэрбум төгрөг} \end{aligned}$$

б) 20X0 оны нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл (уурхайн нөхөн сэргээлт) =

$$= \frac{14 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^8} - (5.9 \text{ тэрбум төгрөг}) = 0.6 \text{ тэрбум төгрөг}$$

20X0 оны 12 дугаар сарын 31-ний өдөр буюу уурхайн үйл ажиллагаа эхэлснээс 1 жилийн дараа нөхөн сэргээлтийн нөөц дэх дискаунтын чөлөөлтийг дараах байдлаар бүртгэнэ.

Дт: Хүүгийн зардал 0.1 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц
(үйлдвэрийг буулгах, зайлуулах) 0.1 тэрбум төгрөг

Дт: Хүүгийн зардал 0.6 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц
(уурхайн нөхөн сэргээлт) 0.6 тэрбум төгрөг

Удирдлага нүүрс угаах үйлдвэр болон уул уурхайн хөрөнгийн элэгдлийг 9 жилийн турш жил бүр хүлээн зөвшөөрнө. Шулуун шугамын аргаар тооцсон нүүрс угаах үйлдвэрийн нэг жилийн элэгдэл нь 20.1 тэрбум төгрөг (181.3 тэрбум төгрөг / 9 жил) байна. Уул уурхайн хөрөнгийн (нөхөн сэргээлтийн хөрөнгө) элэгдэл нь нийт нүүрсний нөөц болон олборлосон нүүрсний хэмжээний хоорондын харьцаанаас шалтгаалдаг. Хэрэв компани 20X0 онд нийт нүүрсний нөөц болох 100 сая тонноос 10 сая тонныг нь олборлосон бол 20X0 оны нөхөн сэргээлтийн хөрөнгийн элэгдэл 0.6 тэрбум төгрөг (5.9 тэрбум төгрөг * 10 / 100) байна.

20X0 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нүүрс угаах үйлдвэр болон нөхөн сэргээлтийн хөрөнгийн элэгдлийг (төлөвлөсөн хэмжээний нүүрсийг угаан боловсруулж байгаа гэж үзвэл) дараах байдлаар бүртгэнэ.

Дт: Бараа материал (боловсруулсан нүүрс) 20.1 тэрбум төгрөг
Кр: Хуримтлагдсан элэгдэл (нүүрс угаах үйлдвэр) 20.1 тэрбум төгрөг

Дт: Бараа материал (боловсруулаагүй нүүрс) 0.6 тэрбум төгрөг
Кр: Хуримтлагдсан элэгдэл (нөхөн сэргээлтийн хөрөнгө) 0.6 тэрбум төгрөг

Дээрх жишээний хувьд 20X0 онд ирээдүйн нөхөн сэргээлтийн зардлын өнөөгийн үүрэг хариуцлагад нөлөө үзүүлэхүйц газар, байгаль орчинд нэмэлт эвдрэл гараагүй гэж таамагласан.

Тайлбар жишээ 4: Нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдэл

Ерөнхий мэдээлэл

Тайлбар жишээ 3-ийг үргэлжлүүлэн авч үзье. 20X1 онд компани нь уурхайн талбайн өнгөн хөрсийг нэмж хуулан, ил уурхайн амыг томруулсан бөгөөд ингэснээр 20X0 оны эцэстэй харьцуулахад байгаль орчинд учирсан эвдрэл нэмэгдсэн гэе. Байгаль орчны мэргэжилтэн 20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл эвдрэлд орсон уурхайн талбайг нөхөн сэргээх зардлыг тооцоолсон бөгөөд энэхүү зардал нь 20X1 оны үнээр 12 тэрбум төгрөг (20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх

эвдрэлд орсон уурхайн талбайг нөхөн сэргээх өнөөгийн үүрэг хариуцлагыг ирээдүйд барагдуулах зардлын дүн, одоогийн үнэд суурилан тооцсон) гэж тооцсон.

20X1 онд элэгдэл тооцох арга, уурхайн ашиглалтын хугацаа, дискаунтын түвшин болон инфляцын түвшинд аливаа өөрчлөлт ороогүй гэж үзье.

Нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдлийг хүлээн зөвшөөрөх нь

20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл тайлбар жишээ 1-д дурдсан бүртгэлийн зарчим үйлчилнэ. Тиймээс 20X1 оны дискаунтын чөлөөлт болон хөрөнгийн элэгдлийг тооцоолж, бүртгэсэн.

20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр удирдлага газар, байгаль орчинд учирсан нэмэлт эвдрэл болон түүний нөхөн сэргээлтийн зардлын тооцооллыг тусгахын тулд нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Дараах томъёогоор нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдлийг тооцоолно.

Нөөцийн нэмэгдэл

$$= \frac{\text{Шинээр тооцсон зардлын ИҮЦ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{Үлдэж буй хугацаа}}} - \frac{\text{Өмнө тооцоолсон зардлын ИҮЦ}}{(1 + \text{дискаунтын түвшин})^{\text{Үлдэж буй хугацаа}}}$$

$$\text{Нөөцийн нэмэгдэл} = \frac{12 \text{ тэрбум төгрөг} \times (1 + 0.05)^7}{(1 + 0.1)^7} - \frac{14 \text{ тэрбум төгрөг}}{(1 + 0.1)^7} =$$

$$= 8.7 \text{ тэрбум төгрөг} - 7.2 \text{ тэрбум төгрөг} = 1.5 \text{ тэрбум төгрөг}$$

20X1 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нөхөн сэргээлтийн нөөцийн нэмэгдлийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

Дт: Уул уурхайн хөрөнгө (нөхөн сэргээлтийн хөрөнгө)	1.5 тэрбум төгрөг
Кр: Нөхөн сэргээлтийн нөөц (уурхайн нөхөн сэргээлт)	1.5 тэрбум төгрөг

20X2 оноос эхлэн хөрөнгө болон нөөцийн нэмэгдлийг харгалзан үзэж, гүйцэтгэлийн хувийн жингийн аргыг ашиглан тооцох элэгдэл болон дискаунтын чөлөөлөлтөөс үүсэх санхүүгийн зардлыг дахин тооцоолно.

НАЙМ. САНХҮҮГИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ОРОЛЦОО

Дараах хүснэгтэд нөхөн сэргээлтийн нөөцийг тооцоолох болон нягтлан бодох бүртгэлд тусгах үйл явц дахь санхүүгийн удирдах албан тушаалтнуудын нийтлэг үүрэг оролцоог тусгасан.

Үе шатууд	Санхүүгийн удирдах албан тушаалтнуудын оролцоо
Нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг тодорхойлох	- Уурхайн хөгжүүлэлт болон ашиглалтын явцад үүсэх байгаль орчныг цэвэрлэх, нөхөн сэргээх үүрэг хариуцлага байгаа эсэх болон тайлант үеийн эцэс дэх энэхүү үүрэг хариуцлагын цар хүрээг тодорхойлох. [4.1, 4.2, 6.1.1, 6.1.2 дугаар зүйл] - Үүрэг хариуцлага хүлээж байгаа эсэх болон түүний цар хүрээг тодорхойлохдоо холбогдох хууль, тогтоомжийг харгалзан үзэх. [4.1, 4.2, 6.1.1, 6.1.2 дугаар зүйл]
Тусгай нарийн мэргэжлийн мэдлэг болон мэргэжилтний хэрэгцээ	- Аж ахуйн нэгжид зохих ур чадвар, туршлага бүхий дотоод мэргэжилтэн байгаа эсэх болон хөндлөнгийн нарийн мэргэжлийн зөвлөх ажилтан ажиллуулах шаардлагатай эсэхийг үнэлэх. [5.2, 5.3, 6.1.10 дугаар зүйл] - Мэргэжилтнийг сонгож, гэрээ байгуулах. [5.2, 5.3, 6.1.10 дүгээр зүйл] - Мэргэжилтний нөхөн сэргээлтийн зардлыг тооцоолох ур чадвар, чадамжийг үнэлэх, мэргэжилтний гүйцэтгэх ажлын цар хүрээг тодорхойлох. [5.3, 5.4, 6.1.4 дүгээр зүйл]
Хэмжилт: Нөхөн сэргээлтийн зардлын тооцоолол	- Ихэнх тохиолдолд мэргэжилтнүүд нь нөхөн сэргээх зардлыг одоогийн үнэ дээр үндэслэн тооцдог. [5.3 дугаар зүйл] - Тооцоололд сонгон ашигласан арга, таамаглал болон өгөгдлийн зохистой байдлыг хянах. Энэхүү хяналтыг хэрэгжүүлэхдээ тайлагналын өдрөөрх уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчин, техник эдийн засгийн үндэслэл болон одоогийн уурхайн төлөвлөгөөг харгалзан хянан үзэх. [5.5, 5.6, 5.7 дугаар зүйл] - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, одоогийн уурхайн төлөвлөгөө болон эвдрэлд орсон газар, байгаль орчны талбайг тооцоололдоо харгалзан үзсэн эсэхийг хянах. [6.1.2, 6.1.4 дүгээр зүйл]
Хэмжилт: Нөхөн сэргээлтийн зардлын ирээдүйн үнэ цэнэ ба тэдгээрийг зарцуулах цаг хугацаа	- Ирээдүйн нөхөн сэргээлтийн зардлыг тодорхойлохын тулд санхүүгийн удирдах албан тушаалтнууд ирээдүйн инфляцын түвшнийг тохирох хувилбаруудаас сонгох хэрэгтэй. [5.8 дугаар зүйл] - Мөнгөн урсгалын цаг хугацаанд нөлөө үзүүлэх уурхайг хаах хугацаа болон ижил төстэй үйл ажиллагаатай холбоотой гаргасан мэргэжлийн үнэлэмжийг хянах. [6.2.3, 6.2.4 дүгээр зүйл] - Мөнгөн урсгалын хүлээгдэж буй хугацаа болон одоогийн үнэ дээр үндэслэн тооцсон мөнгөн урсгалд ашиглах инфляц болон инфляцын хэрэглээг хянах. - Инфляцын таамаглал нь нөхөн сэргээлтийн зардлын тооцооллын таамаглалтай (жишээлбэл: валют, эдийн засгийн орчин гэх мэт) нийцэж байгаа эсэхийг хянах. [6.2.5 дугаар зүйл]
Хэмжилт: Нөхөн сэргээлтийн зардлын	- Мөнгөн урсгал эсвэл дискаунтын түвшний аль нэгийг нөхөн сэргээлтийн нөөцтэй холбоотой эрсдэлээр тохируулах шаардлагатай. Санхүүгийн удирдлага нь энэхүү эрсдэлийн тохируулгыг хянаж үзэх шаардлагатай. [6.2.8, 6.2.9 дүгээр зүйл]

Үе шатууд	Санхүүгийн удирдах албан тушаалтнуудын оролцоо
өнөөгийн үнэ цэнэ	- Валют, хүүгийн түвшин, эрсдэл болон түүнтэй адилтгах хүчин зүйлүүдийг харгалзан нөхөн сэргээлтийн нөөцийн ирээдүйн мөнгөн урсгалд ашиглах дискаунтын хувь хэмжээг тооцоолох. Мөн тооцсон дискаунтын түшингийн зохистой байдлыг хянах. [6.2.6, 6.2.8, 6.2.9 дүгээр зүйл] - Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоолох, тооцооллын үр дүнг хянан үзэх. [6.2.7 дугаар зүйл] - Ашигласан гол таамаглалууд болон үнэлэмжийн (дискаунтын түвшин, инфляцын түвшин, мөнгөн урсгал гарах цаг хугацаа гэх мэт) үндэслэлтэй байдлыг тодорхойлох үүднээс мэдрэмжийн шинжилгээг хийх. [5.10 дугаар зүйл]
Нөхөн сэргээлтийн нөөцийн анхны хүлээн зөвшөөрөлт	- Нягтлан бодох бүртгэлд тусгахаас өмнө гүйцэтгэх удирдлагаар нөхөн сэргээлтийн нөөцийн тооцооллыг хянуулан, холбогдох зөвшөөрөл авах. - Гүйцэтгэх удирдлагаас зөвшөөрөл авсны дараа нөхөн сэргээлтийн нөөц болон Үндсэн хөрөнгө эсвэл Уул уурхайн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэх. [6.3.1 дүгээр зүйл] - Нөхөн сэргээлтийн нөөцийн анхны хүлээн зөвшөөрөлттэй холбоотой журналын бичилтүүдийг хянах. [6.3.1 дүгээр зүйл]
Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн бүртгэл: Нөхөн сэргээх хөрөнгийн элэгдэл	- Үндсэн хөрөнгө эсвэл уул уурхайн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн хөрөнгийн тайлант үеийн элэгдлийг уурхайн ашиглалтын хугацаа болон тайлант үеийн олборлолтын мэдээг ашиглан тооцох. Уурхайн ашиглалтын хугацаа, тайлант үеийн олборлолтын мэдээ нь нөхөн сэргээлтийн зардлын тооцоолол болон уурхайн төлөвлөгөөтэй уялдаатай байх ёстой. Энэхүү хөрөнгийг ихэвчлэн гүйцэтгэлийн хувийн жингийн аргыг ашиглан элэгдүүлдэг. [6.4.1 дүгээр зүйл] - Элэгдлийн тооцоолол болон ашигласан таамаглалуудыг удирдлагаар хянуулсны дараа нөхөн сэргээлтийн хөрөнгийн элэгдлийг хүлээн зөвшөөрч, холбогдох журналын бичилтийг хийх.
Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн бүртгэл: Нөхөн сэргээлтийн нөөц дэх дискаунтын чөлөөлөлт	- Нөхөн сэргээлтийн нөөцийн дүнг жил бүр дискаунтын чөлөөлөлтөөр нэмэгдүүлэх ёстой ба энэхүү чөлөөлөлтийн дүнг тооцоолох. [6.4.1 дүгээр зүйл] - Дискаунтын чөлөөлөлтийн нөлөөгөөр нөхөн сэргээлтийн нөөцөд орж буй өөрчлөлтийг бүртгэх (санхүүгийн зардал болон нөөц). [6.4.1 дүгээр зүйл] - Тухайн тайлант үед ашигласан дискаунтын түвшний зохистой байдлыг хянах, шаардлагатай бол шинэчлэх. [6.4.1 дүгээр зүйл]
Нөхөн сэргээлтийн нөөцийн тооцооллын өөрчлөлт	- Хүлээгдэж буй нөхөн сэргээлтийн нөөцийн хамгийн сайн тооцооллыг хийж чадаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд тайлагналын өдөр бүр нөхөн сэргээлтийн нөөцийг хянах. Мөн ашигласан таамаглал зохистой байдал болон уурхайн төлөвлөгөө, хууль тогтоомж, дүрэм журамд орсон

Үе шатууд	Санхүүгийн удирдах албан тушаалтнуудын оролцоо
	өөрчлөлтийг нөхөн сэргээлтийн нөөцөд тусгасан эсэхийг хянах. [5.12, 5.13, 6.1.5, 6.4.2 дугаар зүйл] - Нөхөн сэргээлтийн нөөцийг дахин тооцохдоо нөхөн сэргээлтийн зардлын тооцоолол болон хэмжилтийн үндсэн зарчмуудыг мөрдсөн эсэхийг хянах. [Дээр дурдсан үе шатууд] - Нөхөн сэргээлтийн нөөцөд орсон өөрчлөлттэй холбоотой журналын бичилтийг хийх, хянах. [6.4.3 дугаар зүйл]
Өмнөх тайлант үед хийсэн тооцооллын буцаан хянах хяналт	- Өмнөх тайлант үед хийсэн тооцоолол нь үндэслэлтэй байсан эсэхийг хянахын тулд бодит үр дүнг өмнөх тооцоололтой харьцуулан буцаан хянах хяналтыг гүйцэтгэх. [5.14 дүгээр зүйл] - Өмнөх тайлант жилийн тооцоолол болон бодит зардлын зөрүүг одоогийн тайлант үеийн тооцоололдоо харгалзан үзэх. [5.14 дүгээр зүйл]
Баримтжуулалт	- Зардлын тооцоололд ашигласан гол таамаглалууд, мэргэжилтний гүйцэтгэсэн ажлын үнэлгээ болон бусад санхүүгийн тооцооллуудыг дэмжих нотолгоо, баримтжуулалтыг бүрдүүлэх. [5.9 дүгээр зүйл] - Нөхөн сэргээлтийн нөөцийн тооцоололтой холбоотой дэмжих материалууд болон эдгээртэй холбоотой үндэслэлийг баримтжуулах. [5.15 дугаар зүйл]
